

Монголчууд бид төрт ёсны 2000 гаруй жилийн баялаг түүхтэй ард түмэн билээ. Түүхэн цаг хугацааны явцад монголын төр, түүний байгуулал, хэлбэр хэв маяг өөрчлөгдөн шинэчлэгдэж байсан ч төрт ёсны уламжлал, залгамж чанараа алдалгүй хадгалж явсаар өдгөөг хүржээ. Манай улсад статистикийн алба нь өнө эртний бөгөөд хөгжил дэвшлийн энэхүү урт замыг туулж ирэв.

Завхан аймаг анх 1923 онд Хантайшир уулын аймаг нэртэйгээр байгуулагдаж, ардын засаг байгуулсаны дараа анх удаа 1923 онд нийт улсын хүн ам, мал, хөрөнгийн тооллого явуулсан байна. Энэ тооллогыг Засагт хан аймагт 1923 оны зун явуулж аймаг хошуудын тооллогын комисс байгуулж, аймгаас хошуу, шавиудад төлөөлөгч томилон нарийн зохион байгуулалт, нэлээд хатуу хяналтаар гүйцэтгэж тооллогыг газар дээр нь гардан зохион байгуулсан хүмүүс нь хошуу, шавийн эрх баригчид, багийн дарга нар гүйцэтгэсэн байдаг. Хошуудын тамгын газар, багийн дарга нар тус багт тооллого үнэн зөв явагдсан тухайгаа баталгаа бичиг гаргаж өгсөн байдаг. Тэр үед тооллогоор аймгийн бүх хошуу, шавь, өртөөд, харуулын жас эдгээрийн нийт өрх, хүн ам мал хамтатган үзэхэд бүх өрх 11350, сум 75, баг 226, арван гэр 1135, хүн ам 54762 болж малын хувьд 779202 толгой байжээ. 1921 оны эцсээс эхлэн хүн амын тоо мэдээ авах ажлыг малын тоо бүртгэлтэй хамтатган явуулж, хүн амын тооллогын хэлбэр агуулга ч сайжирч тэр үеийн улс төр, эдийн засгийн гол зорилт болж байсан хувьсгалыг гүнзгийрүүлж, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт хийх, феодалын эрх ямбыг хязгаарлах, ард анги, ядуучуудын амьдрал байдлыг дээшлүүлэхэд төр, засгаас авах арга хэмжээг боловсруулах үндэс болж байсан. Мөн орон нутгийн захиргаа, сум, баг, аравтыг байгуулахад хүн амын тоо мэдээ чухал материал болж, тухайн аймаг хошууд ашиглаж байсан.

1924 оны 11 сард хуралдсан улсын анхдугаар Их хурлаас баталсан үндсэн хуульд улсын аливаа тоо бүртгэх явдлыг тогтоохыг хуульчилан баталж, дотоод яамны илтгэлийг сонсоод гаргасан тогтоолд “Улсын бүх тоог бүртгэх явдал маш нарийн чухал болох тул одоо мөнхүү яамнаа Тоо бүртгэх хэлтсийг нэмэн байгуулж, уг хэргийг эрхлүүлэн явуулбал зохино” гэж заасны дагуу улсын тоо бүртгэлийн ажлыг дагнан эрхлэх Тоо бүртгэх хэлтэс 1924 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Дотоод яамны дэргэд байгуулагдаж хэлтсийн даргаар гүн Дэмбэрэл, орлогч, хоёр жинхэнэ бүртгэгч, хоёр бичээч нийт 6 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ.

Статистик бүртгэлийн ажлыг аймагт 1931-1944 онд аймгийн яамны мал, тариалангийн хэлтэс, 1944-1947 онд төлөвлөгөөний хэлтэс, 1948-1960 онд төлөвлөгөөний комисс, 1960 оноос эхлэн тоо бүртгэлийн товчоо, суманд 1931-1944 онд сумын нарийн бичгийн дарга, 1946-1954 онд 80 мянгаас доош малтай суманд нарийн бичгийн дарга, дээш малтай суманд сумын орлогч даргыг нэмж, 1954-1956 он хүртэл нийт сумдад малын тоо харгалзахгүйгээр сумын орлогч даргатай болгож, 1956-1961 он хүртэл төлөвлөгч- тоо бүртгэгч, тоо бүртгэлийн улсын байцаагч нэртэйгээр ажиллаж, 1961-2009 онд сумын орлогч дарга, Засаг даргын орлогч, 2010 оноос төрийн сангийн төлөөлөгчид хариуцан ажиллаж байна. БНМАУ-ын Ардын Их хурлын тэргүүлэгчдийн 1960 оны 04 дүгээр сарын 08-ны

өдрийн 94 дүгээр зарлигаар тоо бүртгэлийн газрыг улсын төлөвлөгөөний комиссоос тусгаарлаж, БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн тогтоолоор аймаг, хотод Тоо бүртгэлийн товчоог байгуулжээ. Завхан аймагт Тоо бүртгэлийн ажил аймгийн төлөвлөгөөний байгууллагатай хамт байхад Дашжамц тоо бүртгэгчээр ажиллаж байсан.

Завхан аймагт 1960 онд 6 хүнтэйгээр Тоо бүртгэлийн товчоо анх байгуулагдахад даргаар нь Цогбадрахын Гэцэнпилжээ, мэргэжилтнээр Б.Дашпунцаг, Данзанравжаа, Г.Базарсад, Ичинноров, Норов нар ажиллаж байжээ. БНМАУ-ын сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв хорооны 1960 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 167/99 дугаар тогтоолоор улсын тоо бүртгэлийн ажлыг сайжруулах арга хэмжээг авч хэлэлцэн, сумдын тоо бүртгэгч нарыг Тоо бүртгэлийн улсын байцаагч болгон өөрчилж тэдэнд сумын хэмжээний тоо бүртгэл, хяналт шалгалтын ажлыг хариуцуулжээ. Завхан аймагт 25 суманд улсын байцаагчаас эхлэн сумын Засаг даргын орлогчоор олон жил ажиллаж байсан Дөрвөлжин сумын Төмөр-Очир, Нөмрөг сумын Бэгз, Тэлмэн сумын Гомбо, Ургамал сумын Ядамсүрэн, Яруу сумын Чимэдбалдир зэрэг туршлагатай чадвартай олон ахмадууд идэвх, зүтгэл гарган ажиллаж байсаныг эргэн дурсахад бахархууштай. БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1964 оны 03-р сарын 06-ны өдрийн 111-р тогтоолоор тоо бүртгэлийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай тогтоолоор тоо бүртгэлийн системийн нэрийг өөрчилж хойшид БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн дэргэдэх “Статистикийн төв газар”, аймаг, хотын тоо бүртгэлийн товчоог аймаг, хотын “Статистикийн товчоо” гэж нэрлэж байхаар тогтоосон. Завхан аймгийн тоо бүртгэлийн товчооны даргаар Ц.Гэцэнпилжээ, Б.Дашпунцаг мэргэжилтнээр Г.Зэджав, Д.Балжаа, П.Гончигдорж, Б.Мижиддорж, Г.Баянжаргал, Г.Шонхоон, Д.Оросоо, Отгон, О.Бат-Очир, Д.Жаргал, Д.Пүрэвдорж, С.Сувдаа, Д.Оюунгэрэл, Ц.Гомбо, Г.Лхамаа, Д.Шоовдор, Д.Нинаа, Долгоржав нар тус тус ажиллаж байлаа. Тус аймгийн Статистикийн албаны даргаар Ц.Гэцэнпилжээ /1960-1964/, Б.Дашпунцаг /1964-1968/, С.Тангад/1968-1976/, Г.Бат-Ундрах/1976-1987/, /1989-1992/ Ц.Чанцаа/1987-1989/ Д.Пүрэвдорж /1992-1994, 1997-2009/ Х.Баярлхагва /1994-1996/, С.Жанцанхорол /1996-1997/, Д.Оюунгэрэл /2009-2016/, 2016 оноос Б.Цэгмид ажиллаж байна.

1960 оноос мэдээ тайланг аль болохоор төвлөрүүлэх арга хэмжээнд шилжиж байсан энэхүү цаг үед үйлдвэрлэлийн нэр төрөл, иргэний бүртгэлүүд, малын ашиг шим, амьдын жин, мал жигнэлт цөцгийн тос, хөдөө аж ахуйн нэгдлийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, малын хашаа барилт, материал бэлтгэлт, татан авалт, хөдөлмөр, цалин хөлс зэрэг 20 шахам мэдээ тайланг шинээр гаргадаг болсон төдийгүй жил бүрийн мал хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын тооллого, 1963, 1969, 1979, 1989, 2000, 2010 онуудад хүн ам, орон сууцны тооллогуудыг аймаг, орон нутагтаа амжилттай зохион байгуулж явуулсан. Тус хэлтэс нь монгол орныхоо хөгжлийн түүх, дэвшил, өөрчлөлтийг илэрхийлж ирээдүй хэтийн төлөвийг тодорхойлох үндсэн мэдээллийг бүрдүүлсэн 10 дахь удаагийн, XXI зууны анхны хүн ам, орон сууцны тооллогыг Завхан аймагт зохион байгуулахад аймаг, сумдын комисс идэвх зүтгэл, чармайлт гарган санаачлагатай ажилласаныг үнэлж Монгол улсын Засгийн газрын “Өргөмжлөл”-өөр шагнагдсан. 1967 оноос нийгмийн нийт

бүтээгдэхүүн, цэвэр бүтээгдэхүүний тооцоог үйлдвэрлэлийн болон хуваарилалтын аргаар тооцон эхлэж, үйлдвэрлэлийн үндсэн фонд, түлш эрчим хүчний хүн амын мөнгөн орлого, зарлага, хөдөлмөрийн нөөцийн балансуудыг зохиох ажлыг хийж, 1964-1977 онд машин, тоног төхөөрөмжийн болон үндсэн фондын тооллого, дахин үнэлэлтийн ажлыг зохион байгуулан явуулсан юм. Ард түмний аж амьдралын байдлыг судлах ялангуяа хүн амын хэрэглээ түүний бүтцийг нарийн судлаж, жижиглэн худалдаалах үнийг тогтвортой байлгах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинг судлах явдал 1960-аад оны дунд үеэс хурцаар тавигдаж, Статистикийн төв газарт өрхийн төсвийн судалгааны тасаг анх нээж, 11 аймагт 1000 өрхийг судалгаанд хамруулсанаас аймгийн Тосонцэнгэл, Шилүүстэй, Яруу сумдад 75 өрхийг хамруулан явуулж, өрхийн төсвийн статистикчээр Гончиг, Санжсүрэн, Дорлиг нар ажиллаж байлаа. Одоо ч энэхүү ажил олон сумдыг хамран “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа” нэртэйгээр явагдаж байна. Уг судалгааны мэдээлэлд үндэслэн монгол улсын хүн амын амьжиргааны байдал, ядуурлын түвшинг жил бүр улс, бүсийн түвшинд тооцон гаргаж ирсэн бөгөөд 2014 оноос эхлэн ядуурлын түвшинг хоёр жил тутамд аймгийн түвшинд тооцох боломжтой болж байгаагаараа онцлог юм. Түүнчлэн ажиллах хүч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд эмэгтэйчүүд, эрүүл мэнд нөхөн үржихүй зэрэг түүвэр судалгааны ажлууд явагдаж байна. Ажиллах хүчний судалгааны гол зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажилгүйдлийн шалтгааныг улирлаар тодорхойлон гаргаж, ажиллах хүчний шалгуур үзүүлэлтүүдийг үндэсний хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэлээр тооцож, төрийн бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад шаардлагатай, үнэн бодит статистикийн мэдээллийг бий болгоход оршдог. Одоогоор эдгээр судалгааг манай хэлтсийн мэргэшсэн судлаач Н.Дорждагва, Э.Нямдорж нар хариуцан гүйцэтгэж байна. Мөн 2012 оноос 3 жилийн хугацаатайгаар ҮСХороо, Герман улсын DiwBerlin эдийн засгийн хүрээлэнтэй хамтран баруун гурван аймагт хэрэгжүүлж буй цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал судалгаа нь амжилттай хэрэгжиж дууссан. Манай орны бүртгэл тооцооны ажлын механикжуулалт хэд хэдэн үеийг дамжин хөгжиж, 1924-1940-өөд он хүртэл бүртгэл тооцоо гар ажиллагаагаар явагдаж байсан түүх бий. 1974 онд аймгийн хэмжээний үйлдвэр аж ахуйн газрын регистржүүлэх ажил, хөдөлмөр цалин хөлсний статистик мэдээлэл, малын хөдөлгөөний тайлан, эрүүлийг хамгаалахын статистикийн зарим мэдээллийг боловсруулах програм мөрдөгдөж эхлэлийг тавьсан үе байдаг. 1982 онд статистикийн мэдээллийн теле боловсруулалтын системд зориулж Польшийн Мера-100 хэрэглэгчийн цэгийн микро машиныг аймагт суурилуулан Цэрэндолгор, Д.Оюунгэрэл нар теле боловсруулалтын системийг ашиглахад бодит хувь нэмэр оруулсан аймгийн дэвшилтэт техник, технологийн ашиглалтын анхны сэхээтнүүдийн нэг юм. Монгол улс 1992 оноос Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банкны гишүүн болсноор зах зээлийн орнуудын жишигт тохирох үзүүлэлтээр мэдээлэл гаргаж өгөх зэрэгцүүлсэн судалгаа явуулах шаардлагаар төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед бүрэлдсэн бүртгэл мэдээллийн тогтолцоог зайлшгүй шинэчлэх ажил хийгдсэн. Юуны өмнө төвлөрсөн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх зориулалттай олон мэдээ тайлангуудыг цомхотгох, давтамжийг цөөлөх ажил багагүй хийгдэж ирсэн. Зах зээлийн эдийн засгийн шинэ харилцаа нь Монгол улсад статистикийн үйл ажиллагааг

боловсронгуй болгож хуульчлан батлахыг зүй ёсоор шаардаж байв. Иймд 1994 онд УИХ-аас “Статистикийн тухай” МУ-ын хуулийг батлан гаргаж 1997, 2004, 2006, 2007, 2009, 2010 онд шинэчлэн найруулсан нь статистикийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо, үйл ажиллагааны зарчмыг дэвшилтэт шинэ шатанд гаргасан байна. Статистикийн үйл ажиллагааг хараат бус, бие даасан зарчмын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээнд төвлөрүүлэн эрхэлж, үнэн бодит, чанартай мэдээлэл судалгаагаар хэрэглэгчдийг хангаж, статистикийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж байна. Монгол улсын Их хурал 1997 онд улсын Статистикийн албаны хуулийг шинэчлэн баталсан нь манай улсад статистикийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг хуульчлан тогтоож өгсөн нь тус албаны цаашдын хөгжилд чухал үйл явдал болсон билээ. Аймгийн статистикийн албанаас хөдөлмөр бүтээлээрээ шалгарч төрийн дээд шагнал хөдөлмөрийн гавъяаны улаан туг, Алтан гадас одонгуудаар Д.Балжаа, Д.Пүрэвдорж Алтан гадас одонгоор Г.Базарсад, Г.Бат-Ундрах, хөдөлмөрийн хүндэт медалиар С.Сувдаа нар шагнагдаж Монгол улсын Статистик бүртгэлийн тэргүүний ажилтан цол тэмдгээр хэлтсийн ажилтан С.Тангад, Г.Бат-Ундрах, Д.Балжаа, Д.Пүрэвдорж, Х.Баярлхагва, С.Сувдаа, Баянтэс сумын “Дэлгэрэх амьдрал” нэгдлийн нягтлан бодогч Жамсранжав, Сонгино сумын “Энхтайван” нэгдлийн нягтлан бодогч Чойжилжав, Идэр сумын “Шинэ цэцэрлэг” нэгдлийн нягтлан бодогч Дашдэлэг зэрэг сумын орлогч дарга нар шагнагдсан. Одоо Статистикийн хэлтэс нь 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Хэлтсийн дарга Б.Цэгмид, ахлах мэргэжилтэн Д.Батнасан, мэргэжилтэн Т.Лхагвасүрэн, А.Өнөрбат, Б.Энхмаа, гэрээт ажилтан Ц.Сайнбаяр, судлаач Н.Дорждагва, Э.Нямдорж, жолооч Х.Бүрэнбаатар нар ажиллаж байна. Монгол улсын статистикийн салбарын хэмжээнд 2011, 2012 оны ажлаараа улсад 3-р байр, 2013 онд 2-р байр, 2014 онд 5 дугаар байр, 2015 онд 1 дүгээр байранд шалгарсан өндөр их амжилттайгаар ажиллаж байна. Энэ онд хэрэглэгчдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, интернэтээр хийх тархаалтыг сайжруулах, WWW.NSO.MN, WWW.1212.MN, WWW.ZAVKHAN.NSO.MN сайтуудыг сурталчилан ажиллаж байна.